



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/074/НА-СТА-ТХН

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.mn

Аудитын менежер: Б. Долгорсүрэн

Утас: 261885 Цахим хаяг: dolgorsuren.b@audit.mn

Ахлах аудитор: С.Отгонхорлоо

Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloo.s@audit.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн “Конфиденсе Аудит” ХХК-ийн

Захирал: П.Ариунаа

Утас: 99994990 Цахим хаяг: info@confidenceaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 07/883
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргээгдэх эрчим хүчний халаалтын системийн туршилтын төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төслийн гэрээнд заасны дагуу тайлант онд гадаадын 2 зөвлөх сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулж, 1,183,808.1 мянган төгрөгийн гэрээг байгуулан 544,403.5 төгрөгийн төлбөрийг төлж, зөвлөхөөс оршин суугч бус этгээдийн татварыг суутган улсын төсөвт төвлөрүүлсэн боловч НӨАТ-ыг суутгах талаар гэрээнд тусгаагүй байна.

Аудитын гол асуудал

Азийн хөгжлийн банк, Монгол Улсын Засгийн газартай байгуулсан 2,000.0 мянган ам.долларын тусламжийн гэрээний дагуу 2023 онд төслийн эхний санхүүжилтийг авч, 2024 оны 3 дугаар сараас үйл ажиллагааг эхлүүлж, Азийн хөгжлийн банкны Сэргээгдэх эрчим хүчний төслийн ажилтнууд хавсран гүйцэтгэж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	682,052,732.75	193,136,398.31
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	682,052,732.75	193,136,398.31
312	Төрийн сангийн нэгдсэн данс /төгрөгөөр/	-	120,575.00
312	Төрийн сангийн нэгдсэн данс /гадаад валютаар/	682,052,732.75	193,015,823.31
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	682,052,732.75	193,136,398.31
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	682,052,732.75	193,136,398.31
51210	Өмнөх үеийн үр дүн	-	682,052,732.75
51220	Тайлант үеийн үр дүн	682,052,732.75	(488,916,334.44)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	682,052,732.75	193,136,398.31

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	694,198,000.00	368,129,085.71
122002	Хандив тусламжийн орлого /гадаад/	694,198,000.00	366,089,085.71
120009	Бусад орлого	-	2,040,000.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	86,774.75	856,124,635.19
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	86,774.75	856,124,635.19
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	-	20,940,909.09
210101	Үндсэн цалин	-	20,940,909.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	2,617,613.63
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	-	2,617,613.63
2104	Хангамж бараа материалын зардал	-	1,937,000.00
210401	Бичиг хэрэг	-	1,937,000.00
2107	Томилолтын зардал	-	21,306,600.00
210702	Дотоод томилолт	-	21,306,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	86,774.75	807,282,512.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын төлбөр-Зөвлөх үйлчилгээ	86,774.75	807,282,512.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,040,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,040,000.00
3	ҮЙЛ АЖИЛАГААНЫ ҮР ДҮН	694,111,225.25	(487,995,549.48)
4	ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	(12,058,492.50)	(920,784.96)
225004	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит)	12,058,492.50	920,784.96
6	ҮЙЛ АЖИЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	682,052,732.75	(488,916,334.44)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

			/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	694,111,225.25	368,129,085.71	
122002	Хандив тусламжийн орлого /гадаад/	694,111,225.25	366,089,085.71	
120009	Бусад орлого	-	2,040,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН			
21	Бараа, үйлчилгээний зардал	-	-	
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	-	20,940,909.09	
210101	Үндсэн цалин	-	20,940,909.09	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	-	2,617,613.63	
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	-	2,617,613.63	
2104	Хангамж бараа материалын зардал	-	1,937,000.00	
210401	Бичиг хэргийн материал	-	1,937,000.00	
2107	Томилолт, зочны зардал	-	21,306,600.00	
210702	Дотоод албан томилолт	-	21,306,600.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	807,282,512.47	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	807,282,512.47	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,040,000.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,040,000.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	694,111,225.25	(487,995,549.48)	
8	САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
225001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	12,058,492.50	920,784.96	
9	САНХҮҮГИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(12,058,492.50)	(920,784.96)	
10	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	682,052,732.75	(488,916,334.44)	
11	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	682,052,732.75	
12	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	682,052,732.75	193,136,398.31	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

			/төгрөгөөр/	
ҮЗҮҮЛЭЛТ	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн		
2022 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	-	-		
Тайлант үеийн үр дүн	682,052,732.75	682,052,732.75		
2023 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	682,052,732.75	682,052,732.75		
Тайлант үеийн үр дүн	(488,916,334.44)	(488,916,334.44)		
2024 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	193,136,398.31	193,136,398.31		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,287,005,000.00	854,084,635.19	432,920,364.81	66.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	890,205,000.00	854,084,635.19	36,120,364.81	95.9
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	890,205,000.00	854,084,635.19	36,120,364.81	95.9
2101	Цалин хөлс нэмэгдэл урамшуулал	22,850,000.00	20,940,909.09	1,909,090.91	91.6
210101	Үндсэн цалин	22,850,000.00	20,940,909.09	1,909,090.91	91.6
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	2,857,000.00	2,617,613.63	239,386.37	91.6
210201	Тэтгэврийн даатгал	1,942,900.00	1,779,977.26	162,922.74	91.6
210202	Тэтгэмжийн даатгал	228,500.00	209,409.09	19,090.91	91.6
210203	ҮОМШӨ даатгал	114,300.00	104,704.55	9,595.45	91.6
210204	Ажилгүйдлийн даатгал	114,300.00	104,704.55	9,595.45	91.6
210205	Эрүүл мэндийн даатгал	457,000.00	418,818.18	38,181.82	91.6
2104	Хангамж, бараа материалын зардал	1,965,000.00	1,937,000.00	28,000.00	98.6
210401	Бичиг хэрэг	1,965,000.00	1,937,000.00	28,000.00	98.6
2107	Томилолт, зочны зардал	32,513,000.00	21,306,600.00	11,206,400.00	65.5
210702	Дотоод албан томилолт	32,513,000.00	21,306,600.00	11,206,400.00	65.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	830,020,000.00	807,282,512.47	22,737,487.53	97.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	830,020,000.00	807,282,512.47	22,737,487.53	97.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	396,800,000.00	-	396,800,000.00	-
220001	Барилга байгууламж	396,800,000.00	-	396,800,000.00	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,287,005,000.00	366,089,085.71	920,915,914.29	28.4
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	1,287,005,000.00	366,089,085.71	920,915,914.29	28.4
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	1,287,005,000.00	366,089,085.71	920,915,914.29	28.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		682,052,732.75		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		193,136,398.31		
	Ханшийн тэгшитгэлийн гарз		920,784.96		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5	5		100.0
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4		100.0
620003	Үйлчлэх ажилтан	0	0		

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитаар нийцлийн асуудалтай холбоотой 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомж						
Төслийн гэрээнд заасны дагуу тайлант онд гадаадын 2 зөвлөх сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулж, БНЭУ болон ХБНГУ-ын 2 иргэнтэй 1,183,808.1 мянган төгрөгийн гэрээг байгуулан 544,403.5 төгрөгийн төлбөрийг төлж, оршин суугч бус этгээдийн татварыг суутган улсын төсөвт төвлөрүүлсэн боловч НӨАТ-ыг суутгах талаар гэрээнд тусгаагүй байна.	1	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	1	-